

**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР
ДОТООД АЛБАН БИЧИГ**

Огноо: 2017.09.12

Дугаар: 49

Газар, хэлтсийн нэр: Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Хаана: Нэгжийн дарга нарт

Утга: Аргачлал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал шинэчлэн батлагдсаныг танилцуулахаар хүргүүлж байна.

Хавсралт - 13 хуудастай

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 У.МӨНХЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 17 өдөр


Дугаар А/189

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.2 дахь заалт Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.
2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын үр нөлөөг дээшлүүлэхийг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н. Жавхлантөгс/-т даалгасугай.
3. Энэхүү аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
4. "Аргачлал батлах тухай" Хууль зүйн сайдын 2014 оны А/01 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



С.БЯМБАЦОГТ

A/189

**Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг,
байгууллагын хяналт- шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Зорилго

1.1. Энэхүү журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хөгжлийн бодлогын баримт бичиг (цаашид "бодлогын баримт бичиг" гэх) холбогдох эрх зүйн актын хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэхэд мөрдөнө.

1.2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага (цаашид "агентлаг, байгууллага" гэх) нь дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

1.2.1. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн актын хэрэгжилт, явц, тэдгээрийн дунд болон урт хугацааны зорилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөөг тооцох;

1.2.2. Хууль зүй, дотоод хэргийн бодлогын хэрэгжилт, явц, зорилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөөг тооцох;

1.2.3. Агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, гүйцэтгэл, дунд болон урт хугацааны үр дүн, үр нөлөөг сайжруулах;

1.2.4. Агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтэд үндэслэн бодлогын хувилбар, санал зөвлөмжийг боловсруулж удирдлагад бодлогын дэмжлэг үзүүлэх.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим,
хамрах хүрээ**

2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1. шударга, хараат бус байх;

2.1.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;

2.1.3. хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

2.1.4. хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх;

2.1.5. хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

2.1.6. хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх;

2.1.7. хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан хариуцдаг байх.

2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаа багтана:

2.2.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт дараах баримт бичиг хамаарна:

- 2.2.1.1. Монгол Улсын хууль;
- 2.2.1.2. Улсын Их Хурлын тогтоол;
- 2.2.1.3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;
- 2.2.1.4. Ерөнхийлөгчийн зарлиг;
- 2.2.1.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;
- 2.2.1.6. Засгийн газрын тогтоол;
- 2.2.1.7. Ерөнхий сайдын захирамж;
- 2.2.1.8. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;
- 2.2.1.9. Засгийн газрын албан даалгавар.

2.2.2. Бодлогын баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:

- 2.2.2.1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
- 2.2.2.2. Төрөөс баримтлах бодлого;
- 2.2.2.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
- 2.2.2.4. Бүсчилсэн хөгжлийн бодлого;
- 2.2.2.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр;

2.2.2.6. Үндэсний хөтөлбөр;

- 2.2.2.7. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
- 2.2.2.8. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт;
- 2.2.2.9. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
- 2.2.2.10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
- 2.2.2.11. Дэд хөтөлбөр;
- 2.2.2.12. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

3.1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага нь үйл ажиллагаа болон бодлогын зорилтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна.

3.2. Хууль зүй, дотоод хэргийн яам нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, агентлаг, байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

3.3. Энэхүү журмын 4.2-т заасан үүргийг агентлаг, байгууллагын дарга, (захирал) нар тус тус хариуцна.

3.4. Агентлаг, байгууллагын Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

3.5. Тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж байгууллагын чиг үүрэг, бүтэц, орон тооны хязгаарт нийцсэн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц бүрэлдэхүүнтэй байна.

3.6. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчид тавих шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан хүнийг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалд томилно:

3.6.1. хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр болон тухайн салбарт гурваас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

3.6.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байх;

3.6.3. баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх.

Дөрөв. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөлт, тайлан хугацаа

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" болон энэхүү журмын дагуу хийнэ.

4.1.1. Агентлаг, байгууллагын тухайн жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан нь дараахь хавсралттай байна.

4.1.1.1. тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;

4.1.1.2. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;

4.1.1.3. байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан;

4.1.1.4. шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ;

4.1.1.5. байгууллагын шударга байдлын үнэлгээ;

4.1.1.6. хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт;

4.1.1.7. хэрэглэгчийн үнэлгээний тайлан.

4.1.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд тухайн ажил үүргийн шалгуур үзүүлэлт, хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг тодорхой заана.

4.1.3. Хөндлөнгийн үнэлгээг явцын болон эцсийн үнэлгээний аль ч шатанд хийж болох бөгөөд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

4.1.4. Агентлаг, байгууллага нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20.1-д заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Хөндлөнгийн үнэлгээ, байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах зардлыг байгууллагын төсөвт тусган батлуулсан байна.

	Хугацаа	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын үйл ажиллагааг тайлагнахдаа Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 6-дүгээр хавсралтаар батлагдсан хугацаанд мөн журмын 2-9 дүгээр хавсралтын дагуу ирүүлнэ.
	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын байр жил бүр Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнгийн үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөлд танилцуулна.	
	Хэрэглэгчийн үнэлгээ	
	1. Агентлаг, байгууллагаас иргэдэд үзүүлдэг үйлчилгээний талаар жилд нэг удаа хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх бөгөөд түүнийг хөндлөнгийн байгууллага гүйцэтгэнэ.	
	2. Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхтэй холбогдон гарах зардлыг тухайн агентлаг, байгууллага тухайн жилийн төсөвтөө тусгасан байна.	
	3. Хэрэглэгчийн үнэлгээг агентлаг, байгууллагын бодлогын хэрэгжилтийн үнэмлэхүй үнэлгээ болон үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн байгууллагын үйлчлүүлэгчид насанд хүрсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг, эсхүл тухайн байгууллагаас үйлчилгээгч аж ахуйн нэгжийг хамруулан явуулсан санал асуулгын үндсэн дээр судалгаа, судалгааны баазыг үндэслэн гаргах бөгөөд үр дүнг нь өөрчлөхгүй байх.	
	4. Хэрэглэгчийн үнэлгээг судалгаа, хяналт-шинжилгээ болон үнэлгээний үйлчилгээний байршил, ажиллагаа, торийн бус байгууллагын дундаас ажлын туршлага, хүний нөөцийн хувиар чадал зэргийг харгалзан сонгоно. Хөндлөнгийн байгууллагыг сонгох ажиллагааг тухайн байгууллага зохион байгуулна.	
	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй	
	1. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2-т заасны дагуу хийнэ.	
	2. Агентлаг, байгууллага нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг мөн журмын 10 дугаар хавсралтын дагуу ирүүлнэ.	

Тав. Зайны хяналт тавих цахим сан

5.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээх, эрсдэлийг бүртгэх, үнэлэх, хянах, удирдах, арга хэмжээ төлөвлөх, биелэлтийг тооцоход Хууль зүй, дотоод хэргийн яамны зайны хяналт тавих цахим сан (цаашид “цахим сан” гэх)-г ашиглана.

5.2. Хууль зүй, дотоод хэргийн яамны зайны хяналт тавих цахим санг ашиглах зааврыг Төрийн нарийн бичгийн дарга баталж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, байгууллагыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

5.3 Яам, агентлаг, байгууллагын удирдах албан тушаалтан болон хариуцсан албан хаагчид цахим санд өөрийн эрхээр нэвтэрч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлан, эрсдэлийн үнэлгээний тайлантай танилцаж болно.

5.4. Цахим санд мэдээлэл оруулж байгаа байгууллага, албан хаагч мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

5.5. Хууль зүй, дотоод хэргийн яам дор дурдсан асуудлыг хариуцна:

5.5.1. мэдээллийн сан, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагаа болон программ хангамж, системийн зохицуулалт, нэвтрэх эрх олгох асуудлыг зохицуулах;

5.5.2. цахим санд өөрт олгосон эрхийн дагуу бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалт нэг бүрийг хяналтад авах, эрсдэлийг бүртгэх, үнэлэх, удирдах, төлөвлөх, биелэлтийг тооцох асуудлыг хэрэгжүүлэх байгууллагатай холбогдон тайлагнах хугацааг зааж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийх;

5.5.3. цахим санд өөрт оногдсон эрхийн дагуу нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

5.5.4. цахим санд өөрт олгосон эрхийн дагуу эрсдэлийг бүртгэх, үнэлэх, удирдах үйл ажиллагааг хянах, үнэлгээ хийх;

5.5.5. цахим сангийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.

5.6. Яам, агентлаг, байгууллага дараах асуудлыг хариуцна:

5.6.1. Яам, агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжийн болон тухайн асуудал хариуцсан ажилтан цахим санд нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авах, эрсдэлийг бүртгэх, үнэлэх, удирдах, төлөвлөх, биелэлтийг тооцох асуудлуудын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд оруулах;

5.6.2. Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох дээд байгууллагаас өгсөн үнэлгээтэй тухай бүр танилцаж, өгсөн удирдамж, зааврыг мөрдөн ажиллах.

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

6.1. Агентлаг, байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.1.2 Агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

6.1.3. Агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах;

6.1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.

Долоо. Хариуцлага

7.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан агентлаг, байгууллагын Тамгын газрын даргыг Төрийн албаны тухай хуулийн 23.1-д заасны дагуу албан тушаал бууруулах саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах.

7.2. Дараах зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай, Төсвийн тухай болон холбогдох бусад хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ:

7.2.1 энэхүү журмын 3 дахь хэсэгт заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан;

7.2.2. өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй;

7.2.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, тайланг агентлаг, байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй.

1189

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны
тушаалын 2 дугаар хавсралт

АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт		0.6	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт			
	3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт			
	4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ			
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт		0.2	
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт			
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ		0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ			
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ			
	4. Хэрэглэгчийн үнэлгээ			
Ерөнхий үнэлгээ:			1.0	

**ОЮУНЫ ӨМЧ,УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

Үзүүлэлт		хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	Энэ оны гүйцэтгэл	Өсөлт бууралт	Оноо	Хувь
Иргэний улсын бүртгэлийн мэдээ							
Монгол улсын нийт иргэн	нийт	тоо					
Үүнээс:	Эрэгтэй	тоо					
	Эмэгтэй	тоо					
18 ба түүнээс дээш насны иргэн	нийт	тоо					
	Эрэгтэй	тоо					
	Эмэгтэй	тоо					
18-аас доош насны иргэн	нийт	тоо					
	Эрэгтэй	тоо					
	Эмэгтэй	тоо					
Төрсний бүртгэл	нийт	тоо					
	Эрэгтэй	тоо					
	Эмэгтэй	тоо					
Үрчлэлтийн бүртгэл	нийт	тоо					
	Монгол Улсын иргэнд	тоо					
	Гадаад улсын иргэнд	тоо					
Гэрлэлтийн бүртгэл	нийт	тоо					
	анхны	тоо					
	дахин	тоо					
Гэрлэлт цуцалсны бүртгэл	нийт	тоо					
	Захиргааны журмаар	тоо					
	Шүүхийн журмаар	тоо					
Нас баралтын бүртгэл	нийт	тоо					
	Эрэгтэй	тоо					
	Эмэгтэй	тоо					
Гадаадын иргэдийн гэр бүлийн байдлын бүртгэл	нийт	тоо					
	Гэрлэлтийн бүртгэл	тоо					
	Гэрлэлт цуцалсны бүртгэл	тоо					
	Холимог гэр бүлд төрсөн хүүхдийн бүртгэл	тоо					
	Эцэг тогтоолтын бүртгэл	тоо					
	Үрчлэлтийн бүртгэл	тоо					
Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл	Аймаг хот руу бүр мөсөн шилжин явсан	тоо					
	Насанд хүрэгч	тоо					
	Хүүхэд /16-аас доош насны/	тоо					
	Аймаг хотоос бүрмөсөн шилжин ирсэн						
	Насанд хүрэгч	тоо					
	Хүүхэд /16-аас доош насны/						

Өмнө бүртгэлд хамрагдаагүй байсан иргэний бүртгэл /төрөлт, харьяат болсон, харьяалал сэргээсэнээс бусад хүн амын тоонд нэмэгдэх бүртгэл хамаарна./		тоо					
Иргэний цахим үнэмлэх	нийт	тоо					
	Шинээр олгосон	тоо					
	Дахин олгосон	тоо					
	Хугацаа сунгасан	тоо					
Үндэсний энгийн гадаад паспорт	нийт	тоо					
	Шинээр олгосон	тоо					
	Хугацаа сунгасан	тоо					
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээ							
Улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээд мөр01=мөр(02+03)+(05:09)+(11:18)		тоо					
Хувьцаат компани		тоо					
Хязгаарлагдмал хариуцлагатай компани		тоо					
Үүнээс	тоо						
Төрийн бус байгууллага		тоо					
Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар		тоо					
Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар		тоо					
Нөхөрлөл		тоо					
Үүнээс	тоо						
Хоршоо		тоо					
Хадгаламж, зээлийн хоршоо		тоо					
Сан		тоо					
Үйлдвэрчний эвлэлийн байгууллага		тоо					
Шашны байгууллага		тоо					
Хэвлэл мэдээллийн байгууллага		тоо					
Боловсрол, сургалтын байгууллага		тоо					
Эрдэм шинжилгээний байгууллага		тоо					
Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд		тоо					
Улсын бүртгэлд бүртгүүлсэн гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар		тоо					
Улсын бүртгэлээс хасагдсан гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар		тоо					
Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн		тоо					
Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн		тоо					
Хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон		тоо					
Хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг		тоо					
Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээ							
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тоо							
1. Нийт бүртгэлийн тоо							
2. Анхны бүртгэлийн тоо							
Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл	Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл	тоо					
	Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт	тоо					
Газар өмчлөх эрхийн улсын бүртгэл	Төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрхийн бүртгэл						

	Төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт	тоо						
	Газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл	тоо						
3. Гэрээний эрхийн бүртгэлийн тоо		тоо						
Өмчлөх эрх шилжүүлэх гэрээ, хэлцэл	Худалдах, худалдан авах гэрээ	тоо						
	Бэлэглэх гэрээ	тоо						
	Арилжих гэрээ	тоо						
	Гэрээслэл, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	тоо						
	Албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх гэрээ	тоо						
	Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	тоо						
	Хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ, хэлцэл	тоо						
Барьцааны гэрээ, барьцааны эрх дуусгавар болгох бүртгэл	Барьцааны гэрээ	тоо						
	Барьцааны эрх дуусгавар болсныг бүртгэх	тоо						
Бусад гэрээ	Бусад гэрээ /түрээсийн гэрээ, хөлслөх гэрээ, бусад гэрээ дуусгавар болгох г.м/	тоо						
4. Бусад бүртгэлийн тоо		тоо						
Бусад бүртгэл	Бүртгэлд өөрчлөлт оруулах	тоо						
	Урьдчилсан тэмдэглэл хийх	тоо						
	Лавлагаа, мэдээлэл өгөх	тоо						
Хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тоо								
1. Нийт бүртгэлийн тоо		тоо						
2. Барьцааны мэдэгдлийн бүртгэлийн тоо		тоо						
Шинэ гэрээт барьцааны мэдэгдэл	Гэрээт барьцааны мэдэгдэл	тоо						
	Барьцаалуулагчийн тайлбар	тоо						
	Нэмэлт өөрчлөлт	тоо						
	Сунгалт	тоо						
	Цуцлах	тоо						
Өмнө үүссэн гэрээт барьцааны мэдэгдэл	Өмнө үүссэн гэрээт барьцааны мэдэгдэл	тоо						
	Барьцаалуулагчийн тайлбар	тоо						
	Нэмэлт өөрчлөлт	тоо						
Бусад бүртгэл	Гэрчилгээт хайлт	тоо						
Оюуны өмчийн бүртгэлийн мэдээ								
Зохиогчийн эрхийн мэдүүлгийн нийт тоо		тоо						
Шинэ бүтээлийн мэдүүлгийн нийт тоо		тоо						
Үүнээс	Шинэ бүтээлийн шууд мэдүүлсэн дотоодын мэдүүлгийн тоо	тоо						
	Шинэ бүтээлийн шууд мэдүүлсэн гадаадын мэдүүлгийн тоо	тоо						

	Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу мэдүүлсэний тоо	тоо					
Бүтээгдэхүүний загварын мэдүүлгийн нийт тоо		тоо					
Үүнээс	Бүтээгдэхүүний загварын шууд мэдүүлсэн дотоодын мэдүүлгийн тоо	тоо					
	Бүтээгдэхүүний загварын шууд мэдүүлсэн гадаадын мэдүүлгийн тоо	тоо					
	Гаагийн хэлэлцээрийн дагуу мэдүүлсэний тоо	тоо					
Ашигтай загварын мэдүүлгийн нийт тоо		тоо					
Үүнээс	Ашигтай загварын шууд мэдүүлсэн дотоодын мэдүүлгийн тоо	тоо					
	Ашигтай загварын шууд мэдүүлсэн гадаадын мэдүүлгийн тоо	тоо					
Барааны тэмдгийн мэдүүлгийн нийт тоо		тоо					
Үүнээс	Барааны тэмдгийн шууд мэдүүлсэн дотоодын мэдүүлгийн тоо	тоо					
	Барааны тэмдгийн шууд мэдүүлсэн гадаадын мэдүүлгийн тоо	тоо					
	Мадридын хэлэлцээр болон Протоколын дагуу мэдүүлсэний тоо						
Газар зүйн мэдүүлгийн нийт тоо		тоо					
Үүнээс	Газар зүйн заалтын шууд мэдүүлсэн дотоодын мэдүүлгийн тоо	тоо					
	Газар зүйн заалтын шууд мэдүүлсэн гадаадын мэдүүлгийн тоо	тоо					
Улсын бүртгэлийн болон хяналт шалгалтын мэдээ							
Архивын баримтын тоо	Иргэний баримтын архив	тоо					
	Хуулийн этгээдийн бүртгэлийн архив	тоо					
	Эд хөрөнгийн бүртгэлийн архив	тоо					
	Оюуны өмч	тоо					
Олгосон лавлагаа, хуулбар	Иргэний баримтын архив	тоо					
	Хуулийн этгээдийн бүртгэлийн архив	тоо					
	Эд хөрөнгийн бүртгэлийн архив	тоо					
	Оюуны өмч	тоо					
1. Хяналт, шалгалтын нэгдсэн тоо		тоо					
Үүнээс	Графикийн дагуу	тоо					
	Өргөдөл, санал, гомдлын мөрөөр	тоо					
2. Илрүүлсэн зөрчил		тоо					
Үүнээс	Эрх бүхий хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	тоо					
	Захиргааны хариуцлага ногдуулсан тоо	тоо					